

ТӨВ БАНКНЫ ӨДРИЙН ЗЭЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэ журмын зорилго нь банк хоорондын төлбөр тооцооны системийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор Монголбанкнаас банкинд олгох төгрөгийн Өдрийн зээлийн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 “Өдрийн зээл” гэж банк өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон үнээр тухайн өдөрт багтаан буцаан худалдан авах нөхцөлтэйгээр Монголбанкинд худалдах өдрийн репо хэлцлийг хэлнэ.
- 1.3 Энэ журмын 1.2-т заасан үнэт цаасны жагсаалтыг Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба (цаашид ЭУА гэх)-наас тодорхойлон гаргаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 1.4 Өдрийн репо хэлцлийг энэ журмаас гадна Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний холбогдох заалтаар зохицуулна.

Хоёр. Өдрийн репо хэлцлээр олгох зээлийн үндсэн зарчим

- 2.1 Монголбанк өдрийн репо хэлцлээр “Банксүлжээ” системд оролцогч банкинд төлбөр тооцоо гүйцэтгэх мөнгөн хөрөнгө дутагдсан тохиолдолд тухайн банкны хүсэлтээр өдрийн зээл олгоно.
- 2.2 Монголбанк репо хэлцлээр олгосон өдрийн зээлийн үлдэгдэлд хүү тооцохгүй.
- 2.3 Банк репо хэлцлээр авсан өдрийн зээлийг тухайн ажлын өдрийн “Банксүлжээ” систем хаахаас өмнө Монголбанкинд буцаан төлнө.
- 2.4 Банк Монголбанкнаас тогтоосон Заавал байлгах нөөцөд тооцогдох банкны нөөцийг өдрийн турш төлбөр тооцоонд хэрэглэж болох боловч өдрийн эцэст заавал байлгах нөөцийн шаардлагыг хангасан байна.
- 2.5 Монголбанк овернайт репо санхүүжилтийг төлөхөд зориулж өдрийн зээл олгохгүй.
- 2.6 Монголбанк тухайн банкинд Өдрийн зээл олгохоос татгалзах эрхтэй.

Гурав. Өдрийн репо хэлцэл хийх

- 3.1 Банк өдрийн репо хэлцэл хийх хүсэлтээ “Банк хоорондын цахим арилжааны систем” (цаашид БХЦАС гэх)-ээр дамжуулан “Банксүлжээ” системийн ажиллах цагаар Монголбанкны Валют, эдийн засгийн газар (цаашид ВЭЗГ гэх)-т ирүүлнэ. БХЦАС-ээр ирүүлэх боломжгүй тохиолдолд факсаар, эсвэл албан бичгээр ирүүлнэ.
- 3.2 Банк Өдрийн репо хэлцэл хийх хүсэлтээ энэ журмын 1 дүгээр Хавсралтын дагуу бэлтгэх ба дараах мэдээллийг агуулсан байна:
 - 3.2.1 Өдрийн репо хэлцлийн дүн (төгрөгөөр);
 - 3.2.2 Үнэт цаасны төрөл, дугаар, хугацаа;
 - 3.2.3 Үнэт цаасны нэрлэсэн үнэ;
 - 3.2.4 Үнэт цаас эзэмшсэн хоног.
- 3.3 Монголбанкны ВЭЗГ банкнаас ирүүлсэн өдрийн репо хэлцэл хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 минутын дотор шийдвэрлэн, гүйлгээний шийдвэрийг Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх)-т БХЦАС-ээр дамжуулна.
- 3.4 Монголбанкны ВЭЗГ Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-ний хавсралтын дагуу банктай өдрийн репо гэрээ байгуулж, гэрээний нэг хувийг Монголбанкны ТТБГ-т хүргүүлнэ.
- 3.5 Монголбанк репо хэлцлээр олгосон өдрийн зээлийг тухайн банкны дансанд зээл олгосоноос хойш орох хамгийн эхний орлогын гүйлгээгээр төлүүлж, үнэт цаасыг банкинд буцаан шилжүүлсэнээр өдрийн репо хэлцэл дуусгавар болно.
- 3.6 Банк өдрийн репо хэлцлээр авсан өдрийн зээлийг “Банксүлжээ” систем хаахаас өмнө төлж чадаагүй тохиолдолд уг зээлийг Төв банкны овернаит репо санхүүжилтэд шилжүүлэх хүсэлт ирүүлж болно.
- 3.7 Банк энэ журмын 3.6-д заасны дагуу хүсэлт ирүүлсэн тохиолдолд энэхүү репо хэлцлийн харилцааг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй “Төв банкны овернаит репо санхүүжилтийн журам”-ын дагуу зохицуулна.
- 3.8 Банк репо хэлцлээр авсан өдрийн зээлийг төлж чадаагүй, мөн Төв банкны овернаит репо санхүүжилтэд шилжүүлэх хүсэлт ирүүлээгүй бол Монголбанк өдрийн зээл болон үүнтэй холбогдон гарсан аливаа зардлыг барьцааны үнэт цаасаар төлүүлэх арга хэмжээ авна.

3.9 Энэ журмын 3.6-д заасны дагуу овернайт репо санхүүжилтэд шилжих өдрийн зээлийн хэмжээ нь тухайн банкны төлөөгүй өдрийн зээлийн үлдэгдэлтэй тэнцүү байна.

3.10 Монголбанк өдрийн репо хэлцлийг овернайт репо санхүүжилтэд шилжүүлсэн тохиолдолд тухайн банкинд энэ журмын 2 дугаар Хавсралтын дагуу БХЦАС-ээр, эсвэл факсаар мэдэгдэнэ.

Дөрөв. Бусад

4.1 Төв банкны өдрийн зээлийн нягтлан бодох бүртгэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу хийнэ.

4.2 Монголбанкны ТТБГ өдрийн зээлийн тайланг “Банксүлжээ” системээс нэгтгэн гаргана.

4.3 Энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ӨДРИЙН РЕПО ХЭЛЦЭЛ ХИЙХ ХҮСЭЛТ

Огноо:

Зээлдэгч банк

Өдрийн репо хэлцлийн дүн (төгрөгөөр)

Үнэт цаасны төрөл, дугаар

Үнэт цаасны дуусах хугацаа

Үнэт цаасны нэрлэсэн үнэ

Үнэт цаас эзэмшсэн хоног

**БАНКИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ
АЖИЛТНЫ ГАРЫН ҮСЭГ**

Тамга

Санал хүлээн авсан Монголбанкны ажилтан: (гарын үсгийн тайлал)

Санал хүлээн авсан цаг минут:

МЭДЭГДЭЛ

Огноо:

..... банкинд

Танай банк төгрөгийн өдрийн зээлийг төлөөгүй тул хувийн хүүтэй Төв банкны овернайт репо санхүүжилтэд шилжүүлснийг үүгээр мэдэгдэж байна.

Овернайт репо санхүүжилтийн харилцаа нь “Төв банкны овернайт репо санхүүжилтийн журам”-ын дагуу зохицуулагдана.

МОНГОЛБАНКНЫ
ГАЗРЫН ЗАХИРАЛ

.....